



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 44

Мандагловь

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2 дэх хэсгийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7,098,710 /долоон сая ерэн найман мянга долоон зуун арав/ төгрөгийн балансийн үнэтэй 3,272,766.96 /гурван сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун жаран зургаан төгрөг ерэн зургаан мөнгө/-ийн үлдэгдэл өртөгтэй 14 нэр төрлийн 31 ширхэг хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар тусгай зориулалтын дансанд шилжүүлэх, 3,500,000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 22-71 ДУЭ улсын дугаартай Хьюндай аксент маркын автомашиныг хоёрдугаар хавсралтаар акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар)-т дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Хөрөнгө шилжүүлэх, актлах ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын  
03-ний өдрийн ~~4/4~~ тогтоолын нэгдүгээр хавсралт

Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээ

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон огноо	Хэмж их нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагд сан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	26мм-ийн дохионы СПШ	12/31/1909	ш	2	46,800.00	93,600.00	-	93,600.00
2	СВД бууны ПСО-1 дуран	12/31/1909	ш	1	201,600.00	201,600.00	-	201,600.00
3	БО 50x8 дуран	12/31/1909	ш	1	105,000.00	105,000.00	-	105,000.00
4	16 сувагт бичлэгийн техсеремж	12/24/1919	ш	1	750,000.00	750,000.00	437,500.00	312,500.00
5	2 нүдний дуран Barska	12/24/1919	ш	1	500,000.00	500,000.00	291,666.62	208,333.38
6	Автомашинны шилний гэрэл	10/1/1919	ш	1	800,000.00	800,000.00	226,666.61	573,333.39
7	Богино долгионы станц	12/24/1919	ш	10	150,000.00	1,500,000.00	875,000.00	625,000.00
8	Кварцын гэрэл	12/18/1917	ш	1	185,500.00	185,500.00	117,483.46	68,016.54
9	Проекторын дэлгэц	12/24/1919	ш	1	50,000.00	50,000.00	29,166.62	20,833.38
10	Сервир хайрцаг /12U rack/	4/12/1916	ш	1	373,010.00	373,010.00	366,792.97	6,217.03

11	Согтуурал тандагч / AL-1100/	12/24/1919	ш	8	150,000.00	1,200,000.00	700,000.00	500,000.00
12	Ус цэвэршилэгч	12/24/1919	ш	1	90,000.00	90,000.00	52,500.00	37,500.00
13	Хаалга эвдлэгч	12/24/1919	ш	1	250,000.00	250,000.00	145,833.38	104,166.62
14	Шенийн дуран /stealth view/	12/24/1919	ш	1	1,000,000.00	1,000,000.00	583,333.38	416,666.62
	Нийт дүн			31		7,098,710.00	3,825,943.04	3,272,766.96

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын  
03-ний өдрийн // тогтоолын хоёрдугаар хавсралт



Цагдаагийн газрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Удвалзсан он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
			сери	дугаар			арлын дугаар	моторын эзлэхүүн					
3	Суудлын	Хьюндай аксент	ДУЭ	22 71	2006	10.07.07	КМНСМ41А АВU546984	В-1500	275811	3,500,000	-	-	Актлах
<b>ДҮН</b>											<b>3,500,000</b>	<b>-</b>	